

27

БНМАУ-ЫН АРДЫН БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ КОЛЛЕГИ,
УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ГИШҮҮДИЙН ХАМТАРСАН ХУРЛЫН ТОГТООЛ

1987 оны 01 дугаар
сарын 14 ны өдөр

Дугаар 11/10

Улаанбаатар
хот

Сургууль дундын сургалт-
үйлдвэрлэлийн төв бай-
гуулах тухай

Сүхбаатарын районд 1979 оноос туршилтын журмаар ажиллуу-
сан сургууль дундын сургалт-үйлдвэрлэлийн төв нь зарим сургуу-
лийн ахлах ангийн сурагчдад үйлдвэр, аж ахуйн газруудтай хамт-
ран мэргэжил олгох ажлыг зохион байгуулж зохиц амжилтанд хүр-
сэн байна. 1985 оноос 10 дугаар анги төгсөгчдөд мэргэжлийн бэлт-
гэл олгож, мэргэжлийн комиссын шийдвэрээр сурагчдын тодорхой
хувьд нь мэргэжил олгодог боллоо.

Сургууль дундын сургалт-үйлдвэрлэлийн төвийг үйлдвэр, аж
ахуйн газруудын хүч туслалцаатайгаар байгуулж ажиллуулах болод-
цотой болох нь харагдаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад мэр-
гэжлийн бэлтгэл олгох, сургалт-үйлдвэрлэлийн хэлбэр бэхжүүлэх
дэвшилтэт хэлбэр болсон сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажил-
лагааг боловсронгуй болгох зорилгоор БНМАУ-ын Ардын боловсролын
яамны коллегий, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын Сүхбаатарын районд сургууль дундын
сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулан ажиллуулсугай.

2. Ардын боловсролын яамны ерөнхий боловсролын сургуулийн
хэлтэс /н.Дамдинсүрэн/, төлөвлөгөө, их багцлага, материал хан-
гамжийн хэлтэс /н.Даваасамбуу/, Улаанбаатар хотын АДХ-ын гүй-
цэтгэх захиргааны Ардын боловсролыг удирдах газар /н.Батмаг-
най/-т ДААЛГАХ нь:

а/ сургууль дундын сургалт-үйлдвэрлэлийн төвийг бүрэн дунд сургуулийн ангиллаар тоонож зохих журмын дагуу, тэмцэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглүүлж тайлан мэдээ, төлөвлөгөөнд тусгайлан тусгах байх.

б/ сургалт-үйлдвэрлэлийн төвийн түшиглэх үйлдвэр, аж ахуйн газар, сургалтын мөргөлийн чиглэлийг нарийвчлан тогтоох.

Хотын АЗХГЗ-ийн 1989 оны 161 р тогтоол

3. Сургууль дундын сургалт-үйлдвэрлэлийн төв байгуулагдахтай холбогдуулан өүүний захиргаа, аж ахуйн орон тоог Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хорооноос баталсан орон тоонд зохицуулан тогтоон тус төвийн жилийн төсвийг тусгайлан баталж байхыг Ардын боловсролын яамны санхүү, нэгтгэн бодох бүртгэлийн хэлтэс /н.Джаасуран/, Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргааны санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/, Ардын боловсролыг удирдах газар /н.Батмагнай/-т даалгасугай.



БНМАУ-ЫН АРДЫН БОЛОВСРОЛЫН
ЯАМНЫ САЛД *З. Джаасуран*
Б.ДАВААСҮРЭН



УЛААНБААТАР ХОТЫН АХ-ЫН
ХҮРЛЭН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-
ГААНЫ ДАГМА *С.МОНХМАРТАЛ*
С.МОНХМАРТАЛ